

МОНГОЛ УЛС: ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛТ, ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ

Эн тэргүүнд авч хэрэгжүүлэх хөтөлбөрүүд¹

Азийн Хөгжлийн Банк
2006 оны хоёрдугаар сар

¹ Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн техник туслалцааны хүрээнд боловсруулсан “МОНГОЛ УЛС: Гаалийн шинэчлэл, худалдааг хөнгөвчлөх” сэдэвт энэхүү илтгэл тайланг АХБ-ны зөвлөх Д. Амарсайхан, Д. Очирбат, Chan Fook Seng, G. Parayno, Jr. нар болон АХБ-ны даалгаварын менежер Jeffrey Liang нар гаргасан болно. Энэхүү баримтаар илэрхийлсэн үзэл баримтлал нь зохиогчдоос илэрхийлсэн санаа бөгөөд үүнд заавал АХБ түүний Удирдах Зөвлөл, болон зохиогчдын төлөөлж байгаа засгийн газрын байр суурь, бодлого тусгагдсан байх шаардлагагүй. Энэ баримтад тусгагдсан тоон баримтуудын үнэн зөв эсэхэд АХБ-аас баталгаа гаргахгүй бөгөөд тэдгээрийг хэрэглэснээс үүдэн гарах аливаа үр дагаварт хариуцлага хүлээхгүй. Үүнд хэрэглэсэн үг хэллэг, томъёолол нь заавал АХБ-ны томъёололтой нийцсэн байх шаардлагагүй.

I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

A. Гаалийн шинэчлэл, модернизацийн өнөөгийн байдал

Монгол Улсын Засгийн газрын зүгээс гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон худалдааг хөнгөвчлөх чиглэлээр маш их ажлыг хийж байна. Үүнд:

- Мэдээлэл, технологийг хөгжүүлэх болон түүнийг хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй хийж байгаа байдал
- Нийт улс орны хэмжээний болон гол замуудыг барьж байгуулж байгаа явдал нь бага өртөг зардалтай тээвэрлэлт, логистикийг хөгжилд түлхэц үзүүлэх болно
- Бизнесийн болон худалдааг зохицуулах орчин нь тэдгээрт хамаарах лиценз, хяналт шалгалтыг цомхотгож байгаагаар сайжирч байна .

Дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хөнгөвчлөхөд түлхэц үзүүлэх ДХБ-ын болон ДГБ-ын Конвенцуудад нэгдэн орсон явдал нь засгийн газрын зүгээс гаргасан эрс шийдэмгий алхам мөн.

Түүнчлэн гаалийн байгууллагад шинэ барилга байгууламж байгуулахад болон одоо ашиглагдаж байгаа барилга байгууламжуудыг засварлаж сайжруулахад нь санхүүжилт хийж дэмжиж байгаа явдал нь засгийн газрын зүгээс гаалийн байгууллагыг дэмжиж байгаагийн нэг илэрхийлэл юм.

МУГЕГ нь дараах арга хэмжээнүүдийг авах замаар өөрийн үйлчилгээний чанарыг сайжруулах бүхий л хүчин чармайлтыг гаргаж байна. Үүнд:

- Ёс зүйн дүрмийг болон ажилтнуудын ажлын үр дүнг дүгнэх журмыг батлан гаргаж, мөрдүүлж байгаа явдал
- Гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулж улмаар өөрийн улс орны хэмжээнд мэдээлэл, технологийн чиглэлээр тэргүүлэх байр суурийг эзэлж байгаа явдал
- Эрсдлийн Менежмент болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтыг нэвтрүүлсэн нь орчин үеийн гаалийн практик үйл ажиллагаанд нийцэж байна.

B. Шинэчлэл хийхэд цаашид анхаарах гол асуудлууд

Дээр дурдсан болон бусад олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч бизнес эрхлэгчид тодорхой хүндрэлүүдтэй учирсаар байгаа тул Монголын Гаалийн байгууллагын нэр хүнд олон нийтийн дунд унах явдал гарсаар байна.

Худалдааг Хөнгөвчлөх болон Гаалийн байгууллагын шинэчлэлийн чиглэлээр Монголын Гаалийн байгууллагын эрэлт хэрэгцээг тодорхойлох зорилго бүхий, АХБ-ны санхүүжилтээр 2005 онд хэрэгжүүлсэн судалгааны ажлаар гаалийн нэр хүндийг унагаж байгаа гол гол шалтгаануудыг олж тогтоосон. Энэхүү судалгаанд тусгагдсан, гаалийн олон талт үйл ажиллагаанд хамаарах хүндрэл бэрхшээлүүдээс гарах арга замуудаас 20%-ийг ойрын хугацаанд хэрэгжүүлж болох бөгөөд ийм байдлаар цаашид нийт асуудлын 80%-ийг шийдвэрлэх боломжтой. Нэн даруй авах арга хэмжээ нь гаалийн байгууллагын нэр хүндийг өсгөж улмаар хувийн

сектор, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудад ч мөн эерэгээр нөлөөлөх болно.

Түүнчлэн гаалийн зөрчлийг нуун дарагдуулах тухайлбал татварыг бүрэн гүйцэд ногдуулж, барагдуулахгүй байгаа явдалд Монголын Гаалийн байгууллага нэн даруй анхаарлаа хандуулах шаардлага тавигдаж байна. Гаалийн байгууллагын хурааж байгаа татвар нь улсын төсөв бүрдүүлэлтэд зонхилох байр суурийг эзэлсээр байгаа бөгөөд энэ нь цаашид үргэлжилж улмаар үндэсний үйлдвэрлэгчид гаалийн байгууллагыг бизнесийн хөгжилтөд голлох байр суурь эзэлнэ гэж найдаж байна.

Олон улсын худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хангах талаар Дэлхийн Гаалийн Байгууллагаас 2005 оны 6 сард батлан гаргасан багц стандартыг нэн даруй хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монголын Гаалийн байгууллагын зүгээс экспорт болон дамжин өнгөрөх асуудалд хамаарах үйл ажиллагаануудаа нягтлан үзэж тэдгээрийг өөрчлөн шинэчлэхэд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай болж байна.

Энэхүү стандарт нь мэдээллийг урьдчилан авах, эрсдлийг болон аюулгүй байдлыг тооцох гэх мэт аргуудыг хэрэглэх замаар хууль ёсны дагуу хийгдэж байгаа худалдаанд саад тотгор учруулалгүйгээр эрсдэл ихтэй барааг тухайн нутаг дэвсгэрээс гарахаас өмнө олж илрүүлэх явдлыг дэмжиж байгаа юм. Иймээс Монголын Гаалийн байгууллагаас хувийн секторынхантай хамтарч санал болгож буй системийг нэвтрүүлэх асуудлыг яаралтай шийдвэрлэхгүй бол дээр дурдсан шаардлага болон Эдийн засгийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн ажил үйлчилгээ эрхлэгчид(AEOs)-ийг дэмжих систем нь эргээд Монголын экспортлогчдод бараагаа хүргэж байгаа улс орны нутаг дэвсгэрт хүндрэл бэрхшээлтэй учрах байдлыг бий болгоно.

Энэ хоёрдугаар сараас хүчин төгөлдөр үйлчилж эхлэх Киотогийн Шинэчилсэн Конвенцийн Монголд үзүүлэх үр нөлөөг зайлшгүй судалж үүнд баримтлах байр суурийг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү Конвенцийг соёрхон батлахтай холбоотой асуудлыг хэлэлцэж байх явцад АНУ-ын Олон Улсын Бизнесийн Зөвлөлөөс дараах сануулгыг гаргаж байсан. Үүнд: “Гаалийн байгууллагыг олон улсын стандартад нийцүүлэх хурдацтай алхмаас тухайлбал ДГБ болон ДХБ-аас боловсруулан гаргаж, мөрдөж байгаа арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээгүй Гаалийн байгууллага нь шинэ бизнес, худалдаа болон хөрөнгө оруулалтыг татах боломжийг үгүй болгож гаалийн үр бүтээлч бус үйл ажиллагаанаас үүдэн гарах өртөг, зардлыг багасгах аргагүй болно” гэсэн байна.

С. Орчин үеийн гаалийн байгууллагын үйлчилгээний гол онцлогууд

Улс орнуудын хувьд гаалийн байгууллагын гүйцэтгэх үүрэг харилцан адилгүй байдаг хэдий ч гаалийн шинэчлэл, модернизацийн эн тэргүүн зорилтуудыг тодорхойлоход түлхэц өгөх үзүүлэлтүүдийг нэвтрүүлж, хэрэгжүүлснээр бий болох үлгэр жишээ гаалийн байгууллагыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Хууль ёсны дагуу улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч болон барааны хөдөлгөөнд аль болох бага саад тотгор учруулах замаар улсын төсөв бүрдүүлэх, хууль ёсыг сахиулах үндсэн үүргийнхээ тэнцлийг маш сайн хадгалж байгаа
- Гаалийн хяналт тавих, гаалийн хууль дүрмийг сахиулах ажиллагааг эрсдлийн менежмент, бүрдүүлэлтийн дараах зарчимд тулгуурлан хийх замаар хууль ёсны дагуу улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч болон барааны хөдөлгөөнийг хөнгөвчилж байгаа
- Мэдээлэл технологийг бололцооныхоо дээд хэмжээгээр хэрэгжүүлж, үйлчилгээгээ ил тод, үнэн зөв, хурдан шуурхай байлгаж, төсөвт хор хохирол учруулах болон зөрчилт хамрагдах барааг маш сайн тодорхойлж тогтоон, арга хэмжээг Гаалийн үйлчилгээг олон газар нэгэн зэрэг хүргэдэг арга барилыг авч хэрэгжүүлж байгаа
- Орчин үеийн бизнес явуулж буй арга ажиллагааг дэмжиж, тэдгээрт саад тотгор учруулалгүйгээр, төсөв бүрдүүлэх, хууль сахиулах зорилгоор тавих хяналтын ажлаа хэрэгжүүлэх зөв арга замыг сонгон ажиллах боломжийг олгох эрх зүйн орчин бүрдсэн байгаа
- Ил тод, шударга орчин бүрдүүлэхэд нөлөөлөх хүний хүчин зүйлийг маш сайн хөгжүүлж тэдгээрийг орчин үеийн гаалийн арга ажиллагаанд сургаж, мэргэшүүлсэн байгаа
- Гаалийн хяналтын дагуу тавигдаж байгаа шаардлагыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, тэдгээрт хамаарах хариуцлагыг хамтран хүлээх олон нийтийн үүргийг ойлгуулах үүднээс тэдэнд байнга өгч тэдэнтэй хамтран ажиллаж, харилцан санал солилцож байгаа
- Гаалийн горимыг уялдуулах, хялбаршуулах тухайлбал олон улсын худалдааг хөнгөвчлөх, худалдааны аюулгүй байдлыг хангах, гаалийн зөрчилтэй тэмцэх зорилгоор бусад орны ялангуяа бүс нутгийн гаалийн байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа зэрэг болно.

D. Шинэчлэлийн талаарх заавар зөвлөмжүүд

Гаалийн байгууллагыг шинэчлэх талаар маш олон заавар зөвлөмж, гарын авлагууд бичигдсэн. Үүнд Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах талаар 600 гаруй стандарт, практик зөвлөмжийг агуулсан Киотогийн Шинэчилсэн Конвенцийг иш татаж болно.

Ерөнхийд нь дүгнэж хэлэхэд ийм заавар зөвлөмжүүд нь шинэчлэлийн хөтөлбөрийг нэгтгэх замаар дараах зүйлсийг агуулсан байдаг. Үүнд:

Шинэчлэл, Модернизацийн Хөтөлбөрийг эхлүүлэх гол асуудал болох судалгааны ажлыг маш өндөр түвшинд хийх

Эрх зүйн шаардлагад нийцсэн орчин бүрдүүлэх

Хүний Нөөцийн Хөгжлийн талаар баримтлах бодлого боловсруулах

Ил тод, шударга байдлыг сайжруулах

Эрсдлийн Менежментийг хэрэгжүүлэх

Гаалийн үнэлгээний асуудалд шинэчлэлт хийх

Барааны Гарал Үүслийн дүрмийг хялбаршуулах

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хянах системийг сайжруулах

Дамжин өнгөрөх тээвэрлэлтийг хөнгөвчлөх

Олон улсын худалдааны аюулгүй байдлыг хангах асуудлыг сайжруулах

Мэдээлэл, Холбооны технологийг хөгжүүлэх

Санхүүгийн болон бусад эх үүсвэрүүдтэй холбоотой үүдэн гарах шаардлагуудыг эс тооцон авч үзэхэд дээрх асуудлуудыг авч хэрэгжүүлэх ажил нь урт удаан цаг хугацаа шаардсан, хүндрэл бэрхшээл ихтэй асуудал юм. АХБ-наас гаргасан судалгаанд тусгагдсан анхаарал хандуулах гол асуудлуудад тулгуурлан шинэчлэлийн стратеги төлөвлөгөө гаргах нь Монголын гаалийн байгууллагад хэрэгтэй бөгөөд үүнд өнөөг хүртэл олсон амжилтад тулгуурлан хийгдэх шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах байгууллагын чадавхи, нөөц бололцоог тодотгож өгөх нь зүйтэй.

ШИНЭЧЛЭЛ, МОДЕРНИЗАЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ЭН ТЭРГҮҮНД ТАВИГДАХ АСУУДЛУУД

АХБ-ны судалгааны хүрээнд Монголын Гаалийн байгууллагын шинэчлэл, модернизацийн чиглэлээр дараах асуудлуудыг эн тэргүүнд тавигдах ёстой гэж дүгнэв. Үүнд:

Гаалийн эрх зүйн асуудлаар

- Улсын хилээр нэвтэрч байгаа бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалтыг зуун хувь хийх шаардлагыг өөрчилж ийм хяналт шалгалтад хамаарах барааг тооцож онилох техник арга ажиллагаа болон Эрсдлийн Менежментийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх эрхийг Гаалийн байгууллагад өгөх асуудлыг тусгах байдлаар Гаалийн хуулийн 34 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах
- 34 дүгээр зүйлд оруулах өөрчлөлт нь эзэнд нь олгосны дараа (гаалийн бүрдүүлэлтийн дараа) тавигдах гаалийн хяналт шалгалтад (бичиг баримтын болон биет үзлэгийн) хамаарах тодорхой нөхцлүүдийг баталгаажуулах дүрэм, журмыг гаргах боломжуудыг нээж өгнө.
- Гаалийн байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийн системд болон тодорхой шаардлагад нийцэж байгаа импортлогч, экспортлогчдыг эхний

ээлжинд бүрдүүлэлтийн дараах шалгалтын горимд хамааруулах боломжоор хангах

Цахим сүлжээгээр өгсөн мэдээллийг хуулийн хүчин төгөлдөр баримт болохыг хүлээн зөвшөөрсөн заалтыг хууль, эрх зүйн актуудад тусган өгөх байдлаар мэдүүлэгчийн цахим сүлжээгээр мэдээлэл өгөх асуудлыг хуульчилж өгч улмаар үүнийг хүчин төгөлдөр байлгах үүднээс МУГЕГ-тай гэрээ байгуулах шаардлагыг мэдүүлэгчид тавих

- Цахим мэдүүлэг, төлбөр тооцооны цахим шилжүүлэг, цахим гарын үсэг, цахим мэдээллийг шүүх хуралд нотлох баримт болгон хэрэглэхийг хүлээн зөвшөөрөх, сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх хариуцлага, бичиг баримтыг цаасан дээр үйлдэх явдлыг багасгах, мэдээллийг илгээсэн болон хүлээн авсныг баталгаажуулах, оюуны өмчийг хамгаалах зэрэг чиглэлүүдээр Мэдээлэл Холбооны технологийг хэрэглэх тухай асуудлыг тусгасан шинэ хууль гаргах
- Гаалийн баталгаат агуулах болон баталгаат үйлдвэрийн газрууд ялангуяа гаалийн байгууллагын хяналтад байгаа терминалуудаас ангид байрлах газар руу оруулах бараанд бонд гэх мэт санхүүгийн баталгаа шаардан гаргуулах эрхийг Гаалийн байгууллагад олгох хууль гарган хэрэгжүүлэх замаар гаалийн байгууллагын төсөв бүрдүүлэлтийг сайжруулна. Түүнчлэн татвараас чөлөөлөгдөх импортын бараа болон ре-экспортын бараанд гаалийн байгууллагын зүгээс хүлээн зөвшөөрөгдөх баталгааг шаардаж болно. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэн холбогдох гаалийн горимуудыг зохих ёсны дагуу хэрэглэснээр гаалийн зөрчил, луйвар гаргах оролдлого үгүй болно.

В. ГААЛИЙН ГОРИМУУДТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР

i. Мэдүүлгийн талаар

а. Мэдүүлэх ажилбарыг хурдан шуурхай болгох асуудлыг түргэн шуурхай зохицуулах

Мэдүүлгийн систем удаан ажиллаж байгааг ажиглалтаар тогтоосон бөгөөд үүнийг засаж залруулах үүднээс гараар хийж байгаа үйлдлүүд болон үүнд хамаарах программ хангамжийн аль алинд нь энгийн өөрчлөлт хийх нь ойрын хугацаанд авах нэн тэргүүний арга хэмжээ мөн. Санал болгож байгаа өөрчлөлтүүдээс дурдвал:

- *Гаалийн мэдүүлгийг сүлжээнд холбогдоогүй нөхцөлд илгээх асуудлыг зохицуулсан заалт гаргах* - Мэдүүлгээ өөрийн албан газар дээрээ бөгөлж бичин өгөгдлөө Бүрдүүлэлтийн Нэгдсэн Ажлын Байр (БНАБ)-ны зуучлалын хэсэгт дискээр болон цахим шуудангийн хавсралтаар өгөх боломжийг мэдүүлэгчид олгох үүднээс ийм төрлийн програм хангамжийг олон нийтэд түгээх асуудалд МУГЕГ анхааруулах хандуулах хэрэгтэй. Энэ нь төлбөл зохих татвар, хураамжийн талаарх тооцоог гаргаж авах боломжийг мэдүүлэгчид олгох бөгөөд мөн зуучлагчийн ажлын байранд очиж зарцуулах цаг хугацааг нь хэмнэх болно. Гаалийн мэдүүлгийг сүлжээнд

холбогдоогүй нөхцөлд илгээх боломж олгох програм хангамжийг боловсруулж тараан хураамж авах эрхийг МУГЕГ-аас хувийн компаниудад олгож болгоно.

- *Автомат бүртгэл* – Бүртгэлийн дугаарыг системээс өгч автоматаар бүртгэх ёстой. Зуучлагч мэдүүлгийн өгөгдлүүдийг өгсний дараа эсвэл мэдүүлэгч мэдүүлгийг мэдүүлсэн талаар албан ёсны шийдвэр гаргасны дараа бүртгэлийг баталгаажуулахад анхаарал хандуулах нь зүйтэй. Банктай төлбөр хийх цаашдын мэдээллийг гаргах үүднээс бүртгэлийн дугааруудыг хэвлэж гаргана. Бүртгэлийн дугаар нь мэдүүлгийг албан ёсоор мэдүүлсний илэрхийлэл болох бөгөөд ингэснээр мэдүүлэгч аливаа алдаатай үйлдэлдээ хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Цаасан дээр бичигдсэн мэдүүлэг гээгдэж болох (магадгүй санаатайгаар) боловч албан ёсны цахим хувь нь системд хадгалагдаж байх болно. (Хууль эрх зүйн орчны талаар тусгасан хэсэгт мэдүүлэгчтэй гэрээ байгуулах талаар дурдсан байгааг үзнэ үү)
- *Эзэнд олгох зөвшөөрлийг хооронд нь холбох* – Терминал дээр ажиллаж байгаа ачаа тээш хариуцсан ажилтныг тухайн бараа гаалийн бүрдүүлэлтэд хамрагдсан эсэхийг шалгах, бүрдүүлэлт хийгдсэн барааг гаргах зөвшөөрлийг хэвлэхэд шаардлагатай системээр хангаж өгөх ёстой. Аль эсвэл бүх бүрдүүлэлтийг “гарцан дээр байрлах” компьютер руу дамжуулснаар терминалын ачаа тээшний ажилтан бүрдүүлэлттэй холбоотой мэдээллийг авах боломжтой болно. Ийм систем нь ачааг эзэнд нь олгохтой холбоотой ажиллагааг түргэтгэж мөн хяналтгүйгээр ачаа олгогдох эрсдлийг багасгана.

b. Хэрэглэгчээс-Хэрэглэгч рүү холбосон автомат холболтод хийх өөрчлөлтүүд

- *Мэдүүлгийн маягтыг өөрчлөх* – Мэдүүлгийн өгөгдөлд үндэслэн тооцсон гаалийн татвар, хураамжийн тооцоог гаалийн байцаагч хянаж, дахин тооцсон тооцооноос салангид байлгах нь зүйтэй. Гаалийн мэдүүлгийг бүртгэх явцад татвар, хураамжийн тооцоо тодорхой болсон байх ёстой. Энэ нь ногоон гэрлийн сонголтод хамаарах өгөгдлүүдийг бүрэн автоматжуулах асуудал болон үйлчлүүлэгч өөрсдөө зөв тооцох системийг хөгжүүлэхэд түлхэц үзүүлнэ.
- *Зуучлагчийн програм болон нэгдсэн тарифыг өөрчлөх* – Засгийн газрын байгууллагуудаас шаарддаг гэрчилгээ, лиценз болон уялдуулсан системийн дагуу олгогдох бусад зөвшөөрлийн маягтын мэдээллийн сан нь Гаалийн Бүрдүүлэлтийн Нэгдсэн Системийн (ICCS) нэгдсэн тарифын мэдээллийн сангийн нэг хэсэг нь байх ёстой. Мэдүүлэгт Уялдуулсан Системийн кодоор хязгаарлагдсан/зохицуулалт шаардагдсан бараа бичигдсэн тохиолдолд шаардлагатай зөвшөөрлийн талаарх мэдээллийг зуучлагчийн програм автоматаар дэлгэцэн дээр гаргадаг байвал зохино.
- *Мэдүүлэг боловсруулалтыг дахин зохицуулах* – Системийг цаашид олон улсын шилдэг практиктай уялдуулах, үйлчлүүлэгч өөрөө тооцдог байдалд

хүргэх, Монголын Гааль бүрэн автоматжиж, интернетэд суурилсан болон нэг цахим цонхны үйлчилгээг нэвтрүүлэхэд аажмаар бэлтгэх хэрэгтэй.

- *Төлбөртэй холбоотой асуудлыг дахин шинэчлэх* – Татвар, хураамжийн төлбөртэй холбоотой асуудлыг мэдүүлгийг хүлээн авч бүртгэсний дараагийн шатны асуудал болгон авч үзэж анхаарлаа хандуулах нь зүйтэй. Энэ нь хэд хэдэн давуу талыг бий болгох бөгөөд үүнээс 2-ыг нь дурдвал: (1) төлөгдсөн төлбөрийн дүн нь буруу мэдүүлсэн барааг хураах үндэслэл болох учраас үнэн зөв мэдүүлэх явдлыг дэмжиж, гаалийн зөрчлийг багасгана (2) мэдүүлэг боловсруулах ажиллагааг олон улсын хэм хэмжээнд нийцүүлж Монголын Гаалийг интернэтэд суурилсан, бүрэн автоматжсан орчин үеийн гаалийн байгууллага болгоход бэлтгэнэ.
- *Сонгон шалгалтын програмыг дахин шинэчлэн өөрчлөх* – Гаалийн мэдүүлгийг бүртгэх явцад сонгон шалгалтын програм автоматаар ажиллаж байх ёстой. Ногоон гэрлийн сонголт гэдэг нь мэдүүлэгчийн зүгээс тооцож гаргасан үнийн дүнг банкинд төлбөр хийж болно гэж тооцсон сонголтыг хэлнэ. Нөгөө талаас улаан гэрлийн сонголтын хувьд албан ёсны тооцоог бодож гаргахаас өмнө бүрдүүлэлтийн ажилтны гаргах шийдвэрийг хүлээх хэрэгтэй болно. Түүнчлэн татвар, хураамжийг барагдуулахаар банкинд хийсэн төлбөрийн баримтыг хүлээн авах үед сонголтыг хийж болох хувилбар байж болно. Энэхүү хувилбараар мэдүүлэгч төлбөрт үндэслэн хийх сонголтын талаар урьдчилан мэдэх боломжгүй байх учраас улаан гэрлийн сонголтод хамрагдаж болох мэдүүлэгт өөрчлөлт оруулахаар мэдүүлгээ дахин эргүүлэн татаж чадахгүй.

Төлбөл зохих татвар, хураамж төлөгдсөн эсэх (эсвэл төлөгдөх баталгаа хийгдсэн)-ийг шалгаж тогтоох үед ногоон гэрлийн сонголтын ажилбарыг бүрдүүлэлтийн урт өрөөнд болон барааг эзэнд нь олгох зөвшөөрөл олгогдох үед хэрэглэнэ

- *Ногоон гэрлийн мэдүүлэгт эзэнд нь олгосны дараа бүрдүүлэлт хийх хувилбарыг түр сонгох* – Мэдүүлгийн маягтыг болон дагалдах бусад бичиг баримтыг шаардлагатай арга хэмжээг авахуулах зорилгоор Бүрдүүлэлтийн Дараах Шалгалтын хэлтэст нэн даруй хүргүүлбэл зохино. Зайлшгүй хийх хяналт шалгалтын талаар тусган, шинэчлэн боловсруулагдаж байгаа хуулийн заалтад гаалийн хяналтын бүсээс болон бараа эзэмшигчийн эзэмшлийн газраас барааг гаргахдаа хяналтын талбайд бүрдүүлэлтийн дараах шалгалтыг анхан шатны байдлаар хийх хэлбэрийг тусгаж болно.

Интернэтээр мэдүүлэх мэдүүлэг нь улаан гэрлийн сонголтоос бусад тохиолдолд хэрэглэгчээс хэрэглэгчид хүрсэн автомат, цаасгүй ажиллагааг дэмжсэн, интернэтээр төлбөр хийх асуудалтай нийцэн зохицсон байх ёстой. Ногоон гэрлийн сонголтод хамаарсан цахим баримтыг шүүх ажиллагаанд хуулийн хүчин төгөлдөр баримтаар тооцох тухай заалтыг тусган шинэчлэн боловсруулагдаж байгаа хуулийн заалтад мэдүүлгийн хэвлэмэл маягтыг бусад дагалдах баримтын хамт бүрдүүлэлт хийгдсэний дараах долоо хоногт гарган авч болох тухай тусгаж болно.

- *Гаалийн мэдүүлгийг урьдчилан мэдүүлэх* – Гаалийн хуульд гаалийн мэдүүлгийг урьдчилан мэдүүлж болох тухай заасан байгаа. Энэ заалтыг ялангуяа хил дээр хэрэгжүүлэх боломж олгосноор барааны урсгалыг

түргэтгэж, төсөв бүрдүүлэлтийн алдагдлыг багасгана. Ийм горимыг хэрэглэх байдлыг хөхүүлэн дэмжих зорилгоор түргэвчилсэн ажилбар бүхий урьдчилан мэдүүлэх мэдүүлгийн тусгайлсан сонголт бүхий сувгийг бий болгох хэрэгтэй. Интернэтээр мэдүүлэх боломжийг олгосноор ийм ажилбарыг гадаад улсын нутаг дэвсгэрт, жишээ нь Замын-Үүд рүү оруулах барааг олж нийлүүлж, боож баглан тээврийн хэрэгсэлд ачилт хийгддэг Хятадын Эрээн хотоос хийж болох юм. Ачаа ачсан тээврийн хэрэгсэл хэвлэж авсан мэдүүлгийн хамтаар урьдчилан мэдүүлэх сонголт бүхий сувгаар аль болох түргэн нэвтэрнэ.

ii. Экспорт

Интернэтээр мэдүүлэх боломжийг эн тэргүүний ээлжинд экспортын бараанд олгох нь зүйтэй.

Экспортын бараанд тавих хяналтыг зөрчлийг тандаж илрүүлэх хэлбэрт тулгуурлан тавих ёстой. Экспортлогчийн байранд хяналт шалгалтыг хийх тохиолдолд экспортлогч тодорхой хэсэг барааг шалгуулчихаад өөр барааг экспортолчихож болох талтай. Туршлагаас харахад чингэлгүүдийг лацдаж ломбодсоноор ийнхүү бараа солигдох байдлаас урьдчилан сэргийлэх нөхцөл хангагддаггүй байна. Үүний өөр хувилбар болох гаалийн хяналтын бүсэд барааг оруулж нарийвчилсан үзлэг хийхэд экспортлогчид маш их чирэгдэл учруулдаг байна.

Шинэчлэн найруулж байгаа хуулиар зайлшгүй хийх гаалийн үзлэг шалгалтын оронд экспортын ачилт хийгдэх чингэлгийн талбай дээр анхан шатны үзлэг хийх түргэвчилсэн хяналтын систем зохион байгуулахаар зохицуулж өгөх хэрэгтэй.

Маш их хэмжээний болон үргэлжлэн ачигдаж байгаа экспортын барааны хувьд тогтмол хугацааны (сараар, улирлаар эсвэл жилээр) экспортын мэдүүлгийг хэрэглэдэг болоход анхаарал хандуулах нь зүйтэй. Ийм мэдүүлэгт мэдүүлэх бараа нь тухайн хугацаан дахь ачилтад хамаарна.

Татвар ногдох буюу хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг экспортлоход хяналт тавих үүднээс зөрчлийг тандаж илрүүлэх арга хэлбэрийг түлхүүтэй хэрэглэх нь зүйтэй.

Мэргэжлийн Хяналтын Албанаас болон Стандарт Хэмжил Зүйн газраас экспортод тавих хяналтыг харилцан шилжүүлж хийх байдлаар биш экспортлогчийн үйлдвэрлэлийн байранд барааны чанарыг баталгаажуулах байдлаар хийх ёстой. Ингэснээр хяналт шалгалтын болон чанарын гэрчилгээ нь тодорхой хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Татвар ногдох, худалдааны хориг хязгаарт хамаарах эсвэл олон улсын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл ихтэй барааны ачилтыг зөв

тодорхойлж тогтоох зорилгоор мэдээлэлд дүн шинжилгээ хийж зөрчлийг тандаж илрүүлэх системийг хөгжүүлэх асуудлыг Монголын Гаалийн байгууллага эхлүүлэх нь зүйтэй. Үүнд дэмжлэг авах үүднээс ДГБ-аас техник туслалцаа, бусад хандивлагч байгууллагуудаас туслалцаа хүсэж болно.

Монголын Гаалийн байгууллага нь Багц стандартад тусгагдсан Эдийн засгийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн ажил үйлчилгээ эрхлэгчид(AEOs)-ийн талаарх стандартыг хэрэгжүүлэх зорилгоор худалдааны гол түншлэгчидтэй итгэмжлэлийг харилцан зөвшөөрөх байдлаар экспортлогчидтой хамтран ажиллаж эхлэх хэрэгтэй.

iii. Үзлэг шалгалт

- Эрсдлийг тооцон сонгон шалгалт хийх хувилбарыг сонгох байдлаар барааг 100% шалгадаг шаардлагаас татгалзах
- Биет үзлэг хийх түвшинг хяналт тавих зорилгод нийцүүлэн тогтоох асуудлыг дэмжих зорилгоор гаалийн хяналтын талбай болон терминал бүрд шаардлагатай тоног төхөөрөмжийг зохих ёсны дагуу суурилуулах
- Биет үзлэг, хяналт шалгалтыг бүрдүүлэлтийн дунд хэсэгт бус төгсгөлд нь хийх нь зүйтэй. Бүрдүүлэлттэй холбоотой өртөг зардлыг багасгах аливаа давхардлыг багасгах үүднээс гаалийн хяналтын талбайгаас барааг гаргах үед үзлэгийг хийх нь илүү оновчтой.
- Монголын гааль, Мэргэжлийн хяналтын газар болон Стандарт хэмжил зүйн газрууд зайлшгүй үзлэг шалгалт хийгдэх ёстой, нэмэлт баримт шаардагдах барааны жагсаалтыг Уялдуулсан системийн кодоор нэгдсэн байдлаар шинэчлэн гаргах ажлыг зохин байгуулах хэрэгтэй. Ийм жагсаалт нь Автоматжуулалтын Нэгдсэн Системийн нэг хэсэг байх байдлаар хийгдэж дээр дурдсан шаардлагын талаарх анхааруулгыг мэдүүлэгчид болон гаалийн бүрдүүлэлт хийж байгаа байцаагчид өгөх байдлаар өргөтгөгдсөн байвал зохино.
- Дээр дурдсан байгууллагууд биет үзлэгийг хөнгөвчлөхийн тулд дараах байдлаар нэгдмэл зөвшилцөлд хүрэх нь зүйтэй. Үүнд: (1) статистик түүвэр хийх (2) импортлогчийн байранд очиж барааг буулгах явцад нарийвчилсан үзлэг хийх (3) хяналт шалгалтын үр дүнд дүн шинжилгээ хийх зорилгоор фото зураг авах, видео бичлэг хийх
- Мэргэжлийн хяналтын байгууллага нь барааг гаалийн хяналтад байх явцад гаалийн байгууллагыг орлон биет үзлэгийг хийн барааг борлуулах цэгт, импортлогчийн байранд болон гаалийн бүрдүүлэлтийн дараа аливаа нэг байранд үзлэг шалгалт хийхийг хязгаарлахад анхаарал хандуулах нь зүйтэй.
- Зохицуулалт, хяналт шаардагдсан барааны талаарх мэдээллийг Гаалийн байгууллага мэдүүлгээс авч цаг алдалгүй Мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлэх ёстой. Энэ зорилгоор UAIS нь уялдуулсан системийн тодорхой кодыг агуулсан мэдүүлгийг хүлээж

авсан эсэх талаарх мэдэгдлийг Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэхээр үйл ажиллагаагаа өргөжүүлж болно.

- *Стандарт шаардагдах бүтээгдэхүүний гаалийн горим* – Бүтээгдэхүүний стандартад хяналт тавих, хяналтын зорилгод нийцэж байгаа эсэх талаар Гаалийн байгууллага, Мэргэжлийн Хяналтын газар болон Стандарт хэмжил зүйн газруудын тус тусын хүлээх үүргийг тусгасан хэлэлцээрийг дараах байдлаар хийх нь зүйтэй. Үүнд:
 - Стандарт хэмжил зүйн газар стандартуудыг гаргах, тэдгээрийн үзүүлэлтүүдийг баталгаажуулахад анхаарлаа хандуулна. Тухайн ачилт бүрд гэрчилгээ шаарддаг өнөөгийн практикийг зургаан сар юмуу түүнээс дээшхи тодорхой үечилсэн хугацаагаар гэрчилгээ олгодог байдлаар сольж өөрчлөх нь зүйтэй. Энэ байгууллага нь хүчинтэй бус гэрчилгээтэй эсвэл стандартын шаардлага зөрчсөн бүтээгдэхүүн байгаа эсэх талаарх судалгааг хэрэглэгчидтэй хамтран албан бусаар явуулж болох бөгөөд холбогдох арга хэмжээнүүдийг авахуулах зорилгоор энэ тухай Гаалийн байгууллагад болон Мэргэжлийн хяналтын газарт мэдээлнэ.
 - Зах зээл дээр байгаа стандартын шаардлага зөрчсөн ийм бүтээгдэхүүнүүдэд Мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс шалгалт хийж, борлуулагч/импортлогч-ийг гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийлгэхгүй байх үүднээс барааг нь илрүүлж, хураалгах зорилгоор энэ тухай мэдээллийг Гаалийн байгууллагад мэдээлнэ. Хийгдсэн шалгалт болон зөрчил илрүүлэх ажилбарт үндэслэн сэжиглэгдэж буй байгууллага, компанийг эрсдэл ихтэй үзүүлэлт бүхий мэдээллийн санд хийж оруулж/гаргаж байгаа бараанд нь хамтарсан үзлэг шалгалт хийх тухай саналыг Гаалийн байгууллагад тавьж болно.
 - Стандарт хэмжил зүйн газар нь импорт, экспортын аль алинд нь стандарт болон баталгаажуулалтын гэрчилгээ шаардагдах барааны жагсаалтыг уялдуулсан системийн дагуу шинэчлэн гаргаж Гаалийн байгууллагад болон Мэргэжлийн хяналтын газарт тухай бүрд нь хүргүүлж байх ёстой.
 - Гаалийн байгууллага нь Автоматжуулалтын Нэгдсэн Системийн хүрээнд мэдүүлэх системийг дараах зорилгоор боловсруулж гаргах нь зүйтэй. Үүнд:
 - Уялдуулсан системийн кодыг мэдүүлсэн байдлаар нь шалгаж, тухайн бараанд хамаарах баталгаажуулалтын гэрчилгээ нь хүчинтэй/ хугацаа хэтэрсэн эсэхийг шалгаж шаардлага хангаагүй тохиолдолд энэ тухай импортлогчид аль болох эрт зуучлагч мэдүүлж байх үед мэдэгдэнэ.
 - Стандарт хэмжил зүйн газраас олгосон хүчинтэй/ хугацаа хэтэрсэн баталгаажуулалтын гэрчилгээ бүхий компаниудын мэдээллийн санг үүсгэнэ
 - Бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамааруулахаар хүлээн авсан бүх мэдүүлгүүдийн талаарх мэдээллийг цахим шуудан болон мэдээлэл холбооны холбогдох хэрэгслээр Стандарт хэмжил зүйн газарт болон Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлнэ.

- Стандарт хэмжил зүйн шаардлагыг зөрчих магадлал өндөртэй компаниудын талаарх мэдээллийн сан үүсгэнэ. Зөрчил үйлдэх магадлал ихтэй ийм компаниудын талаарх мэдээллийн санг бараанд бүрдүүлэлт хийх системд сонголт хийх ажиллагаатай холбож өгнө.
- Монгол Улсын хилээр нэвтрэх барааны урсгалд хяналт тавих системийг нэгтгэн уялдуулах, олон улсын стандартад нийцсэн горимд хамааруулах, худалдааг хөнгөвчлөх зорилгоор Гаалийн байгууллага, Мэргэжлийн Хяналтын газар болон Стандарт хэмжил зүйн газруудын оролцоог хэрхэн нэгтгэх асуудлаар техник туслалцаа үзүүлэх хэрэгтэй. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахгүй байх тохиолдолд худалдааг хөнгөвчлөх асуудалд томоохон хүндрэл бэрхшээл учруулах болно.
- Ерөнхийд нь авч үзэхэд эдгээр байгууллагуудын оролцоо хэрхэн нэгтгэгдэн уялдсаныг зохицуулалт болон хяналт шаардагддаг бараа/материалаар тодорхойлж болно.
- Эдгээр төрийн байгууллагууд нь тус тусдаа лабораторитай байснаас гуравдагч талын лабораторийг нэгдсэн байдлаар хэрэглэх нь хязгаарлагдмал нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах боломжийг бий болгохоос гадна өөр өөр лабораториудын дүгнэлт харилцан адилгүй гарсны улмаас үүдэн гарах эрсдлээс зайлсхийх боломжийг олгоно.

iv. Татвар түр хойшлуулах горим

- Дотоодын үйлдвэрлэлд зориулан импортлох түүхий эдийг зөвхөн оруулах байдлаар үйлдвэрийн байрны ашиглах боломжийг хязгаарлах
- Хууль, мөрдөгдөж байгаа дүрэм журмыг зохих ёсны дагуу мөрдөх баталгааг гаргуулах үүднээс гаалийн баталгаат агуулахуудаас баталгааны бонд шаардах
- Татвар, хураамжийг төлөх баталгаа болгож гаалийн баталгаат агуулах руу оруулж байгаа ачилт бүрийг бондод хамруулах

С. Хил дээр хийгдэх үйл ажиллагаанууд, Дамжин өнгөрөхтэй холбоотой асуудал

- *Ачааны машин нэвтрэх хилийн гарцыг бий болгох* – Ачааны машин болон чингэлэг бүхий авто машинуудыг галт тэрэгний болон ердийн авто тээвэр нэвтрэх замаас тусад нь нэвтрүүлж эдгээрт зориулсан тусгай терминалыг барьж байгуулах нь зүйтэй.
- *Ачааны терминал* – Бараанд хийгдэх биет үзлэгийг зохих ёсны дагуу хийх явдлыг дэмжих үүднээс холбогдох тоног төхөөрөмж, шаардлагатай ажиллах хүчин бүхий байгууламж байх ёстой. Замын-Үүдэд чингэлэг шалгах байгууламж байгаа газар гэхдээ замын эсрэг талд ийм терминалыг байгуулах нь зүйтэй.

- *Гаалийн бүрдүүлэлтийг урьдчилан хийх систем* – Ийм систем нь барааг хил дээр ирэхээс өмнө гаалийн бүрдүүлэлтийг (мэдүүлэх, татвар ногдуулах болон барагдуулах) урьдчилан хийх боломж олгож зөвхөн биет үзлэгийг барааг терминалд орсны дараа хийхээр зохицуулж байгаа юм.
- *Интернэтээр мэдүүлэх байгууламжууд* – Хилийн хоёр байгууллагуудын худалдаа, аж үйлдвэрийн танхимуудын хамтын ажиллагааны хүрээнд Хятадын Эрээн хотоос орж ирэх барааг ирэхээс өмнө интернэтээр мэдүүлж, урьдчилан бүрдүүлэлтийг интернэтээр мэдүүлэх байгууламжаар дамжуулан хийж болно.
- *Зөвхөн зорчигчдод зориулсан терминал* – Одоогийн байгаа хилийн хяналтын байгууламжийг зөвхөн зорчигчийн бүрдүүлэлтэд зориулан ашиглах нь зүйтэй. Байгууламжийн дотор талыг зорчигчдын ая тухыг хангасан, найрсаг уур амьсгалыг бий болгох байдлаар өөрчлөн засварлах хэрэгтэй.
- *Дагалдан яваа ачаанд хяналт тавих* – Зорчигчийн терминалд бүрдүүлэлт хийгдэх зорчигчийг дагалдан яваа ачаанд хязгаарлалт тогтоох асуудлыг бодлогоор маш тодорхой зохицуулах ёстой. Ийм хязгаарлалтыг тоон болон үнийн дүнгийн аль алианаар тогтоож өгч болох юм. Эдгээр хязгаарын аль алиныг хэтрүүлсэн тохиолдолд барааны албан ёсны мэдүүлэг бичиж ачааны терминал дээр бүрдүүлэлт хийлгэх шаардлага тавигдана. Бараа ачиж яваа авто тээврийн хэрэгсэлд мөн ачааны терминал дээр бүрдүүлэлт хийнэ. Зорчигчийг дагалдан яваа, албан бус бүрдүүлэлт хийгдэх барааны үнийн дүнгийн дээд хязгаарыг заавал тогтоож өгөх шаардлагатай бөгөөд үүнийг жишээ нь нэг зорчигчид 500 ам.доллартай тэнцэхээр тогтоож өгч болно.
- *Албан ёсны худалдаанд шилжүүлэх хөтөлбөр* – Улсын хилээр нэвтэрч байгаа албан бус барааны хэмжээ үлэмж их хэмжээтэй байгаа түүнчлэн эдгээр нь амьжиргааны эх үүсвэр болж байгаа учраас татвар, хураамж төлөгдсөн албан ёсны худалдаа ямар ашиг тустай болох талаар мэдлэг олгох сургалтын шинжтэй хөтөлбөрүүдийг зохион байгуулах хэрэгтэй.
- *Зорчигчийг дагалдаж яваа албан бус бараанд хяналт тавих газар* – Үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байгаа рентген төхөөрөмжийн (Heimann аппарат суурилуулсан) байгууламжийг хязгаарлагдсан хэмжээнд багтах дагалдаж яваа ачааг ачсан зорчигчийн машин болон жижиг тээврийн хэрэгслийг шалгах зориулалт бүхий хяналтын газраар ашиглаж болох бөгөөд энэ нь жолооч болон барааг аливаа сөрөг үйлдлүүдээс хамгаална.
- *Дагалдаж яваа арилжааны бус бараанд бичигдэх хялбарчилсан мэдүүлэг* – Одоогийг ашиглагдаж байгаа маягтыг дараах байдлаар шинэчлэн өөрчлөх хэрэгтэй. Үүнд: (1) энэхүү маягт нь зөвхөн хязгаарлагдсан хэмжээнд багтах, арилжааны бус бараанд зориулагдсан болох талаар анхааруулга бичнэ. Хязгаарлагдсан хэмжээнээс хэтэрсэн бараанд хилээр нэвтрүүлэх албан ёсны маягт

бичигдэх ёстой (2) Гаалийн байцаагч шийдвэр хэрхэн гаргасан болон төлбөл зохих татварын үнийн дүнгийн талаар бичигдэнэ.

- *Галт тэргийг орж ирэхэд гаалийн хяналт тавих ажиллагаа* – Улсын хил дээр орж ирж байгаа ачааны галт тэргэнд хяналт тавих гаалийн байцаагчийн ажлын үр дүнг хянаж байх хэрэгтэй. Энэ зорилгоор хөдөлгөөнт, томруулагчтай хяналтын камерыг суурилуулж манифест бичигдээгүй ачааг түргэн хугацаанд шалгаж болно. Ачаа ачиж ирсэн галт тэргийг солих зорилгоор чингэлгийн терминал дээр ирсэн үед нарийвчилсан шалгалтыг хийх нь илүү үр дүнтэй.
- *Улсын хилээр нэвтэрч байгаа автомашин болон хөнгөн тэрэгнүүдийн талаарх мэдээллийн сан* – Автомашин болон хөнгөн тэргээр тээвэрлэгдсэн арилжааны бараанд хяналт тавих ажлыг дэмжих үүднээс хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн талаарх лавлагааны системийг хяналт шалгалтын байцаагч ашиглах боломжтой нөхцлөөр хангах ёстой. Мэдээллийн сантай тулгаж байх зорилгоор хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн бичлэг хийх хяналтын камерыг мөн давхар суурилуулж өгөх нь зүйтэй.
- *Шилжүүлэн ачих асуудлыг зохицуулах* – Ачааны терминалын төмөр зам дээрх ачааны тавцантай холбогдох тохиолдолд чингэлэгт тавигдах лац ломбо, хамгаалалтын талаарх шаардлага тавигдахгүй байж болно. Энэ тохиолдолд чингэлгүүдийг ачааны тавцан дээрээс шууд галт тэргэнд шилжүүлэн ачих боломжтой. Эрээн хотод ачигдсан маш их тоо хэмжээтэй барааг Замын-Үүдэд шилжүүлэн ачих зорилгоор тэдгээрийг шууд ачааны терминал дээр авчирч галт тэргэний тээшинд ачих тохиолдолд мөн лац ломбо шаардахгүй байж болно.
- Хэдийгээр e-ТИР-ийн горим, Аюулгүй-ТИР болон ТИР-ийн дагуу хийгдэх дамжин өнгөрөх тээврийг зохицуулах мэдээлэл технологийн бусад системүүдийг ажиллуулах зорилт тавьж байгаа ч эрсдэл ихтэй дамжин өнгөрөх ачаанд хяналт тавих шинэ арга зам хайх зөвлөмжийг Монголын гаалийн байгууллагад өгч байна.
- Бизнесийн болон төрийн байгууллагуудад өргөн хэрэглэгдэж байгаа, сансрын холбоогоор явсан маршрутыг тогтоох технологийг ТИР-ийн бус байдлаар орон нутгийн нөхцөлд хилээс гүний гааль руу илгээгдэж байгаа тээврийн хэрэгслийг хянахад хэрэглэж болох бөгөөд одоо ашиглаж байгаа замын системээр үүнийг ашиглах боломжтой юм. Сансрын холбоогоор хяналтад байх системд хамрагдсан тээврийн хэрэгслээр зөвхөн дамжин өнгөрөх ачааг тээвэрлэж болно гэсэн агуулгатай тушаалыг Гаалийн байгууллагаас гаргаж болно.
- Дамжин өнгөрөх тээврийн мэдээллийг хүлээж авах, барааг хүлээн авагчаас баталгаажуулалт авах, дамжин өнгөрөх зөвшөөрөл олгогдсон гаалийн байгууллагууд руу түлхэх татах технологийг хэрэглэн урьдчилан мэдэгдэл өгөх, тухайн зогсоолд ирсэн тохиолдолд маягыг үндэслэн автоматаар бүртгэх, хяналтын урьдчилсан системээс хазайсан тохиолдолд дохиолол өгдөг мэдээлэл

технологийн системийг Монголын гааль боловсруулж гаргах хэрэгтэй.

- Янз бүрийн баталгаа шаарддаг системтэй холбоотой өртөг зардлыг хэмнэх зорилт нь ТИР-ийг хэрэглэх хөшүүрэг болж өгч болно.
- Дамжин өнгөрөх ачааны хувьд Эрсдлийн Менежментийн системд тулгуурласан ажил хийгдэх ёстой.

Е. Хяналт шалгалтын арга хэлбэр, техник ажиллагаа

i. Эрсдлийн менежмент

Монголын гааль эрсдлийн менежментийн талаар албан ёсны баримт гаргах ёстой. Практик ажиллагааны талаарх гарын авлагад дараах болон бусад зүйлсийг оруулж болно. Үүнд:

- Эрсдлийг тодорхойлох зорилгоор зөрчилд тандалт судалгаа хийх мэдээлэл цуглуулах, эрсдлийн талаарх материал бүрдүүлэх, холбогдох арга хэмжээ авах зэрэг асуудлуудад хувь нэмэр оруулах үүргийг бүх хэлтсүүдэд ерөнхий үүрэг болгож өгөх
- Эрсдлийн менежментэд өөр чиглэлийн хэлтсүүдийн гүйцэтгэх үүргийг тус бүрээр гаргаж тэдгээр нь Эрсдлийн Удирдлага, шуурхай хяналтын хэлтсийн үндсэн үүрэгт хэрхэн хувь нэмэр оруулахыг тодотгох
- Эрсдлийн талаар материал бүрдүүлэх болон сонгон шалгалтын шалгуур үзүүлэлтүүдийг авч болох бүхий л газруудаас мэдээллийн сан бүрдүүлж болно. Зөрчил гарах магадлалтай харилцан давхцах өөр бусад мэдээллийн сангуудыг одоогийн хэрэглэж байгаа мэдээллийн сан дээр нэмж бий болгох хэрэгтэй. Ийм мэдээллийн сангуудад дараах зүйлсийг оруулж болно. Үүнд:
- *Телефон утасны лавлагаа* – Албан газрын телефон утас ч байхгүй компани гаалийн зөрчил үйлдэх өндөр магадлалтай байдаг
- *Бизнес үйл ажиллагааны бүртгэл* – Худалдаа эрхэлж байгаа үйл ажиллагаа нь бизнесийн нөхцөл байдалтай нь нийцэхгүй байх эсвэл албан газрын хаяг нь тодорхойгүй байх, явуулж байгаа үйл ажиллагааны түвшинтэй нийцэхгүй байх зэрэг нь зөрчил гаргах өндөр магадлалыг бий болгодог.
- *Татвар төлөгчийн талаарх мэдээлэл* – Татвар төлсөн талаар ямар нэгэн мэдээлэлгүй эсвэл хэтэрхий бага татвар төлсөн, татвараас зайлсхийгч нь гаалийн зөрчил үйлдэх магадлалтай.
- Урьдчилан бүрдүүлэлт хийхийг дэмжих үүднээс мэдээллийн сангуудыг цахим манифест дахь мэдээлэлтэй тулгах (тухайн ачилтын эрсдлийн түвшинг тогтоох)-д ашиглах нь зүйтэй. Нөгөө талаар цахим мэдүүлгийг цахим сантай тулгах нь бүрдүүлэлтийн ногоон болон улаан гарцыг хэрэглэхэд тус дөхөмтэй болгоно.
- Баглаа боодлын дугаар болон төрөл, жин, барааны нэр, илгээгч, гарал үүсэл, хүлээн авагч гэх мэт гаалийн мэдүүлгийн эгзэгтэй өгөгдлүүдийг мэдүүлгүүдээс автоматаар ялган тооцож тэдгээрийг

эрсдэл ихтэйд тооцох үйлдлүүдийг хийх ажиллагаанд цахим манифестыг ашиглах шаардлагатай.

- Эрсдлийн талаарх материал бүрдүүлж, шигшилт хийж байгаа нэгж, байгууллага нь эрсдэлд байнга дүн шинжилгээ хийж тэдгээрийг шинэчлэн боловсронгуй болгох ба зөрчил илрүүлсэн ажлын үр дүнг хэмжин дүгнэх механизмыг бий болгоно.
Эрсдийн Удирдлага Шуурхай Хяналтын Хэлтсийг бэхжүүлэх зорилгоор:
- Эрсдлийн менежментийн дэвшилтэт арга хэрэгсэл болох мэдээллийг олон эх үүсвэрээс авч хадгалах, олон төрлийн мэдээллээс боловсруулалт хийж шаардлагатай шинэ мэдээлэл гаргаж авах зэргийг хэрэглэх, тэдгээртэй ажиллах чадвар бүхий хүмүүсийг ажиллуулах,
- Эрсдлийн удирдлагын системийг ашиглан томоохон зөрчил илрүүлсэн холбогдох гаалийн газар, хороодыг урамшуулах тогтолцоо бий болгох.
Монголын Гаалийн байгууллагын эрсдлийн удирдлагын системийг боловсронгуй болгох зорилгоор хэрэгжүүлэх төслийн хүрээнд дараах зүйлсийг хийх нь зүйтэй. Үүнд:
- Эрсдлийн менежментийн талаар албан ёсны баримт боловсруулах,
- Урьдчилан бүрдүүлэлт хийхийг дэмжих цахим манифестын болон олон гарцаар хийх бүрдүүлэлтийг дэмжих гаалийн мэдүүлгийн түвшингийн аль алинд нь ачилтын эрсдлийн түвшинг тооцох системийг автоматжуулах

ii. Бүрдүүлэлтийн дараах шалгалт

- Мэдээлэл Холбооны Технологийн шинэ арга хэрэгсэл болох олон төрлийн мэдээллээс боловсруулалт хийж шаардлагатай шинэ мэдээлэл гаргаж авах болон дүн шинжилгээ хийх аргыг хэрэглэн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх сонголтын суурь үзүүлэлт түүнчлэн сонголт хийх аргыг боловсронгуй болгох хэрэгтэй. Орлогын татвараас зайлсхийгчид нь гаалийн татвараас мөн адил зайлсхийх эсвэл гаалийн татвараас зайлсхийгчид орлогын татвараас зайлсхийх магадлалтай байдаг тул ҮТЕГ-ын мэдээллийн сантай холболт хийн НӨТ-ийн төлбөрт тулгалт, харьцуулалт хийх нь сонгон шалгалтын үр дүнг сайжруулна.
- Чанартай цөөн тооны шалгалт явуулж байх нь дээр байдаг. ҮТЕГ-ын аудитын ажилтнуудтай хамтран НӨТ-г аудитын шалгалтыг хийх нь зөрчил илрүүлэх ажиллагаанд ихээхэн дэм үзүүлнэ. НӨТ-ийн (15%) хувь нь импортод ногдох татваруудаас харьцангуй өндөр хувьтайд тооцогдож байгаа учраас НӨТ төлөлттэй холбоотой зөрчил гарах магадлал их байдаг.
- Аудит хийх арга ажиллагаа болон бүрдүүлэлтийн дараах шалгалтын ажилтнуудад аудитын мэдлэг олгох сургалт зохион байгуулахад техник туслалцаа авах шаардлагатай.

iii. Эрэлч нохойн алба

- Эрэлч нохой болон нохой хөтлөгч нарт зориулсан сургалтын хөтөлбөрийн агуулга, стандарт болон заах аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай. Тэсэрч дэлбэрэх бодис болон бусад бодисуудыг илрүүлэх чиглэлээр сургалт явуулах ёстой.
- Засгийн газрын өөр агентлагууд, бүс нутгийн болон бусад орны гаалийн байгууллагын мэргэжил нэгт ажилтнуудтай нь харилцаатай байх боломжийг нохой хөтлөгчдөд олгох хэрэгтэй.
- Нохойн байр, нохойнд арчилгаа үзүүлэх үйлчилгээг сайжруулах шаардлагатай.
- Нохой хөтлөгчөөр ажиллуулах хүнийг сонгох сонголт нь хатуу шалгууртай байж зөвхөн энэ ажилд дур сонирхолтой тийм хүнийг авч ажиллуулах нь зүйтэй.

iv. Бүс нутгийн гаалийн байгууллагуудтай хамтран ажиллах

- Монгол Хятадын хил дээрх Ярант-Такашикены боомт дээр туршиж эхлүүлэхээр төлөвлөж байгаа Хилийн хамтарсан хяналт шалгалтыг Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэнд Сүхбаатар аймгийн Бичигт боомтын хүрээнд өргөжүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Эрдлийн менежментийн үр дүнг дээшлүүлэх үүднээс буруутай этгээд/нийлүүлэгчийн нуусан арга хэлбэр, бусад нарийн ажиллагаануудын талаар болоор үнийн дүнгийн асуудлын хүрээнд бүс нутгийн хэмжээнд мэдээлэл солилцож байвал зохино.
- Гаалийн шинэчлэл, модернизацийн асуудлаар туршлага солилцох боломж олгодог Төв Азийн Бүс нутгийн Гаалийн Хамтын Ажиллагааны Хорооноос зохиогддог арга хэмжээнүүдэд Монголын гаалийн байгууллагаас идэвхтэй оролцдог байдлаа цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй.

Е. Хувийн сектортай хамтран ажиллах: Үүрэг хариуцлагын талаар мэдэгдэж, хариуцлагыг хамтран хүлээх

- Хариуцлагыг хуваалцах асуудал нь улс орнуудын гаалийн байгууллагуудын үйл ажиллагаанд илүү практик байдлаар нэвтэрч байгаа гаалийн техник арга ажиллагаа юм. Энэ нь гаалийн хууль, холбогдох дүрэм журмыг сахиулах үйл ажиллагаанд бизнес, худалдаа эрхлэгчид болон нийт иргэдийг татан оролцуулж тэдний хариуцлагыг дээшлүүлнэ гэсэн үг юм. Хууль сахиулах байдлыг сайжруулах нэг арга хэлбэр бол барааны үнэлгээг тодорхойлоход үйлдвэрлэлийн **бүлэглэлүүдийг** оролцуулах явдал байж болно. Жишээлбэл эргэлзээтэй импортлогчийн мэдүүлсэн тодорхой мэдээллүүдийг хүлээн авмагцаа (байгууллагын нууц задруулахгүй байх хуулийн

заалтын хүрээнд) сайн дураар хүлээн зөвшөөрсөн аливаа нэг үйлдвэрлэгчдийн холбоо руу цахим шуудангаар шууд илгээж барааны үнэлгээг зөв тодорхойлоход тэдний туслалцааг авч болох юм. Нөгөө нэг арга нь удирдлагын зөвлөлийн гишүүний тайлангийн картыг ашиглан тухайн компаний гаалийн төлбөрийг ижил төстэй салбарынхтай (нэгж кг, тарифын жагсаалт болон харьцуулалт хийж болох зарим суурь үзүүлэлтүүдтэй) харьцуулж болно.

- Шууд харилцаанд бага оролцдог хувийн секторуудад тэдгээрийн хүлээх үүрэг хариуцлагынх нь талаар мэдэгдэж байх нь зүйтэй. Иймээс гаалийн хууль, тогтоомжийн систем, үйл ажиллагааны талаар олон нийтэд байнга шинэчилсэн байдлаар мэдээлж байх тохиолдолд гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явдал сайжирна гэсэн үг юм. Ийм арга хэмжээг бизнесийн секторынхан Гаалийн байгууллага болон Гааль эдийн засгийн дээд сургууль хамтран авч хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Улс орнуудын хуулинд тусгагдаж тэдгээрийн гааль болон татварын байгууллагуудад хэрэглэгдэж буй татварыг нөхөн төлүүлэхэд мэдээлэгчдийг ашиглаж, тэднийг шагнаж урамшуулдаг аргыг хэрэглэх нь зүйтэй. Зарим байгууллагууд олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан иймэрхүү аргыг илүү түлхүү хэрэглэдэг. МУГЕГ нь тухайн байгууллагын олон нийтийн дунд унаад байгаа нэр хүндээ сэргээх, гэхдээ гол нь хууль зөрчигчдийг жигшин зэвүүцэх байдлыг нэмэгдүүлэх, хууль зөрчигчийг илрүүлж хатуу хариуцлага хүлээлгэх болно гэсэн мэдээллийг олон түмний ухамсарт хүргэх зорилгоор энэхүү компанид ажилд мэдээллийн хэрэгслийг ашиглахаар шийдэж болно.
- МУГЕГ-аас хувийн секторынхантай ялангуяа худалдаа эрхлэгчидтэй ойр дөт хамтран ажиллах өөр нэг гол чиглэл бол Олон улсын худалдааны аюулгүй байдлыг хангах, худалдааг хөнгөвчлөх асуудлаар ДГБ-аас батлан гаргасан багц стандартыг мөрдөх явдал юм.
- Энэхүү багц стандартын үндсэн гол стратеги нь олон улсын худалдааны нийлүүлэлтийн сүлжээний аюулгүй байдлыг хангах асуудалд гаалийн байгууллагын зүгээс хувийн секторынхныг татан оролцуулахад чиглэгдсэн. Худалдааны нийлүүлэлтийн сүлжээг террорист халдлагаас хамгаалах аюулгүйн баталгааг өндөр түвшинд байлгах амлалт өгөх, эдийн засгийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн ажил үйлчилгээ эрхлэгчид (АЕОs) болон хувийн бизнес эрхлэгчдийг олж тогтоох, тэднийг хөхүүлэн дэмжихэд чиглэгдсэн олон улсын системийг бий болгох хэрэгтэй.

Мэдээлэл Холбооны Технологи, Нэг Цахим Цонхны Үйлчилгээ

- Богино болон дунд хугацаанд хийж гүйцэтгэх ажлын хүрээнд тусгагдсан, гаалийн мэдүүлэг боловсруулах үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах чиглэлээр мэдээллийн технологийн системийн хэрэглээг

өргөжүүлэх явдал нь мэдээлэл холбооны технологийн хөгжлийн эн тэргүүний асуудал мөн.

- Эрсдлийн менежмент, сонгон шалгалт, бүрдүүлэлтийн дараах шалгалтыг олон төрлийн мэдээллээс боловсруулалт хийж шаардлагатай шинэ мэдээлэл гаргаж авах болон дүн шинжилгээ хийх аргуудтай уялдуулах явдлыг бэхжүүлэх хэрэгтэй. Шинэ технологи ашиглахад шаардагдах чадавхийг дээшлүүлэх, оюунлаг мэдлэгийг төлөвшүүлэх асуудал нь худалдааг дэмжих, хөнгөвчлөх, төсөв бүрдүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн практик тэргүүн туршлагауудыг нэвтрүүлж хэрэгжүүлэх угтвар нөхцөл нь болно.
- Манифестийг боловсруулах, гаалийн системээс төмөр замын байгууллагын систем руу шилжүүлэх асуудлаар МУГЕГ, Төмөр Замын Байгууллага хамтарч ажиллах хэрэгтэй. Тээврийн компаниудын өөрсдийн мэдээллийн технологийн логистикийн системээ ашиглан үйлдсэн манифестийн өгөгдлүүдийн мэдээллийг хүлээн авагч, хэрэглэгч нь гаалийн байгууллага байвал зохино. Ингэснээр өртөг зардал өндөртэй алдаа гаргах боломж бүхий өөрсдөө манифест шивэх үйл ажиллагааг халах болно.
- Гаалийн мэдүүлэг болон бусад үйл ажиллагааны логикийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн практик тэргүүн туршлагын философтой уялдуулах асуудлыг ГАМАС-ийг шинэчлэх ажлыг хүлээлгүйгээр өнөөгийн түвшинд хэрэглэгдэж байгаа ГАМАС-ын хүрээнд хийх шаардлагатай.
- Мэдээллийн нэгдсэн автоматжуулсан систем буюу ГАМАС ++ ийг шинэчлэхтэй холбоотой онцлог асуудлуудыг АХБ-наас хийсэн судалгааны 15 дугаар Хавсралтад тусгасан байгаа. Мэдээллийн нэгдсэн автоматжуулсан систем нь гаалийн удирдлагын нэгдсэн систем байх бөгөөд гаалийн бүх газар, хороод ,боомтуудыг ерөнхий газрын төв сервер болон мэдээллийн баазтай шууд холбосон байна.
- Мэдээлэл Холбооны технологийг АХБ-ны судалгааны 16 дугаар Хавсралтад тусгагдсан МХТ-ийн Мастер төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.
- Өнөөгийн түвшинд эхний шатанд бараанд хяналт тавих, бүрдүүлэлт хийхэд оролцдог байгууллагууд болон гаалийн байгууллагын хооронд Нэг Цахим Цонхны үйлчилгээг эхлүүлэх ажлыг хийх хэрэгтэй.
- Зуучлагчид/мэдүүлэгчид болон банкууд өнөөгийн байдлаар Бүрдүүлэлтийн Нэгдсэн Ажлын Байранд хамт байрлаж өөрсдөд нь хамаарах цахим мэдээллийг (барааны мэдүүлэг, банкны төлбөрийн баталгаажуулалт), тээврийн компаниуд ачааны манифестийг гаалийн байгууллагын систем рүү шууд илгээдэг учраас засгийн газрын агентлагуудын олгодог экспорт, импортын лиценз, зөвшөөрлийг ийм маягаар илгээх байдлыг зохицуулах эн тэргүүний зорилтод нийцүүлэн Нэг Цахим Цонхны үйлчилгээг бий болгох асуудал тавигдаж байгаа юм. Нэг Цахим Цонхыг мэдээлэл дамжуулах суваг байдлаар ашиглан

дамжуулах ёстой дараагийн цахим баримт бол ачаа олгогчоос ачаа хүлээн авсан тухай баталгаажуулалт юм.

- Техник туслалцаа үзүүлэх асуудлыг лиценз болон зөвшөөрөл олгох, хяналт тавихтай холбоотой ажлыг зохицуулах зорилгоор Гаалийн байгууллага болон Мэргэжлийн Хяналтын газрын хамтарсан автоматжуулсан системийг бий болгоход хандуулах хэрэгтэй. Мэдээлэл оруулах системийг интернэтээр хийх боломжтой болгож боловсруулагдсан мэдээлэл Гаалийн байгууллага руу автоматаар дамжуулагдаж байх ёстой.
- Эцсийн хувилбараар гарах цахим баримтууд(эхний ээлжинд импортын зөвшөөрөл болон ачаа хүлээж авсан тухай баталгаажуулалт)-ыг ГАМАС-руу дамжуулахаас өмнө гаалийн мэдээллийн суваг (портал) руу хүчинтэй болгох зорилгоор илгээнэ. Нэг цахим цонхны үйлчилгээг олон нийтэд хүргэх эцсийн хэрэглэгч байх ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэмүү өртөг нэмэгдсэн арилжааны үйлчилгээ эрхлэгчдэд тодорхой тоогоор хязгаарлан олгож болно.
- Цаасан мэдүүлэгт хавсрагдсан дагалдах бичиг баримтуудыг шалгах, баталгаажуулах зорилгоор одоогийн ГАМАС системийг хэрэглэн дээр дурдсан цахим баримтуудыг “нягтлан шалгаж” болно.
- Мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийх асуудлыг дэмжих зорилгоор ГАМАС-ийг өргөтгөн шинэчилсэн үед эдгээр цахим баримтуудад боловсруулалт хийх ажиллагаа нь мэдүүлгийн системийн нэг хэсэг болон үл анзаарагдах байдлаар хийгдэнэ.
- Бүрдүүлэлтийн Нэгдсэн Ажлын Байрнаас (БНАБ) цахим баримтуудыг шилжүүлэх ажлыг дараагийн шатанд хийх бөгөөд үүний тулд эхлээд тэдгээрийн LAN холболттой шууд оролтыг нэг цахим цонхоор дамжуулан интернэтэд ачаалж БНАБ-наас гаргана.
- Гааль төвтэй Нэг Цахим Цонхны Үйлчилгээг нэвтрүүлж, ажиллуульж гаалийн газар байгууллагууд “ямар ч үед, аль ч газар” ашигладаг болж эхэлсний дараа Гаалийн байгууллага ийм үйлчилгээг илүү өргөн хүрээнд Худалдааны болон Логистикийн Нэг Цахим Цонх болгох асуудлыг шийдвэрлэж болох юм. Гэхдээ үүнийг хэрэгжүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд худалдааг дэмжих асуудлын цар хүрээг тодорхойлох маш өргөн хүрээтэй судалгаа хийх шаардлагатай. Нэг цахим цонхны үйлчилгээ нь зөвхөн нь худалдааны бичиг баримтыг хялбарчлан, олон төрлийн маягтыг цөөлөх асуудлыг шийдвэрлэх байдлаар хязгаарлагдахгүй бөгөөд мөн худалдааны талаарх мэдээллийн төвлөрсөн баазтай байж шийдвэр гаргах түвшинд хэрэглэгддэг статистикийн мэдээллийг үнэн зөв гаргахад нөлөөлнө.
- Нэг цахим цонхны үйлчилгээнд хамрагдах бүх байгууллагууд хамтдаа үндэсний хэмжээнд худалдааг дэмжих асуудлын цар хүрээг тодорхойлох зорилгоор томоохон судалгаа хийх шаардлагатай. Нэг цахим цонхны үйлчилгээний зорилго нь худалдааны бичиг баримтыг хялбарчлах, олон төрлийн маягтыг цөөлөх, худалдааны талаарх мэдээллийн төвлөрсөн баазтай байж шийдвэр гаргах түвшинд хэрэглэгддэг статистикийн мэдээллийг үнэн зөв гаргах, улсын

хэмжээний худалдааны талаарх мэдээллийг татах асуудлыг хялбарчлах зэрэг юм.

- Дээрх судалгааны хүрээнд гаалийн байгууллага, хувийн болон улсын хэвшлийн оролцогч талуудын үйл ажиллагааг оролцуулан улс орны худалдааны орчинг гүнзгийрүүлэн судална. Түүнчлэн мэдээллийн технологийг ашиглан худалдааны таатай орчинг бий болгоход оролцогч талууд хэрхэн хамтарч ажиллах асуудалд анхаарал хандуулна.
- Энэ судалгаагаар Монгол улсын худалдааны орчинг олон улсын стандартад нийцүүлэхэд шаардагдах худалдааг хөнгөвчлөх стратеги болон мэдээллийн технологийн систем бий болгох талаар санал боловсруулах болно. Түүнчлэн нэг цахим цонхны үйлчилгээг хэрхэн санхүүжүүлэх, хэрхэн удирдаж явуулах талаар тодорхой хувилбаруудыг гарган сонголт хийж хамгийн зохистой хувилбар буюу бизнес моделийг гаргах юм.
- Дээрх судалгааг гадаад, дотоодын тус тус хоёр зөвлөхөөс бүрдсэн олон талын мэргэжлийн баг хийж гүйцэтгэнэ.
- Энэ судалгааг хийх хүмүүсийн удирдамжийг АХБ-ны судалгааны 17-р хавсралтад тусгасан болно.

Хүний Нөөцийг Хөгжүүлэх асуудлаар

i. Хүний Нөөцийн Мэдээллийн сан

- Монголын Гаалийн байгууллага хүний нөөцийн менежменттэй холбоотой ажиллагааг автоматжуулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгч байна. Хүний нөөцийн мэдээллийн санд бүх ажилтнуудын талаарх тодорхой нарийвчилсан мэдээллийг байршуулах нь зүйтэй. Ийм мэдээлэлд хувь хүний өөрийнх нь болон гэр бүлийнх нь тухай мэдээлэл, ажилд томилогдсон/шилжилт хөдөлгөөн хийгдсэн, сургалт, сахилга бат, ээлжийн амралт, өвчтэй байсан зэрэг мэдээллүүдийг багтаана. Эдгээр мэдээллийг нууцын зэрэглэлтэйгээр хадгалах бөгөөд үүнийг зөвхөн шаардлагатай үед холбогдох талууд үзэх боломжтой. Жишээ нь өөрийн ажилтнуудынхаа сургалтын талаар болон амралтын талаарх мэдээллийг авах зорилгоор шууд харьяалах удирдах ажилтан нь ийм мэдээлэлд нэвтэрч болно.

ii. Ажилтнуудын мэдлэг чадавхийг дээшлүүлэх

- Шинэчлэл, модернизацийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр ажилтнуудад шинэ мэдлэг олгох шаардлага бий болно. Шинээр бий болж буй талбаруудад ажиллах ажилтнуудын тоо, тэдгээрийн зэрэглэл, тухайн ажлын байранд шаардагдах мэдлэгийг тооцоолох үүднээс Гаалийн байгууллагын зүгээс Сургалтын Эрэлт Хэрэгцээнд судалгаа явуулах ёстой. Удирдах албан тушаалтан бүр өөрийн удирдлагад байгаа ажилтнуудын сургалтын төлөвлөгөөг гаргаж, тэдгээрийн сургалтын эрэлт хэрэгцээг судлах ажлыг жил бүрээр хийх нь зүйтэй.
- Мэдээлэл Холбооны Технологийн хэрэглээ өсөж байгаа цаг үед компьютер, компьютерийн анхан шатны програмуудыг хэрэглэж чаддаг болгох боломж олгох сургалтад ажилтан бүрийг хамруулах шаардлагатай. Мэдээлэл технологийн ажилтнуудыг үргэлж тэргүүн эгнээнд байлгах зорилгоор шинэ технологи болон гаалийн автоматжуулалтын чиглэлээр мэргэшүүлэн сургаж, тэдгээрийн олж авсан мэдлэгийг гаалийн үйл ажиллагаанд нэвтрүүлж ашиглах хэрэгтэй.
- Гаалийн хил болон нэгж бүр дээр компьютер, принтерийн алдаа болон засвар хийх анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрагдсан ядаж нэг ажилтан байлгах ёстой. Ингэснээр Мэдээлэл технологийн хэлтсийн ажилтнуудыг ийшээ тийшээ явуулж ажиллуулахтай холбоотой гардаг хүндрэл чирэгдлийг багасгана. Монголын Гаалийн байгууллага нь өөрсдийн хэрэглэж байгаа компьютер болон Микрософт Оффис, цахим майл гэх мэт анхан шатны програмуудтай харьцдаг хэрэглэгчидтэй байгууллага болох зорилт тавих хэрэгтэй.
- Мэдээлэл технологийн ажилтнуудыг гаалийн мэргэжлийн сургалтад хамруулах хэрэгтэй бөгөөд ингэснээр гаалийн үйл ажиллагаатай холбоотой хэрэглэгчдэд учирсан хүндрэл бэрхшээлийг түргэн хугацаанд засаж залруулах арга хэмжээ авах боломжтой болно. Мэдээлэл технологийн ажилтнууд хавсарга сургалтад хамрагдсанаар системийг цаашид өргөжүүлэх, шинэ үйлдлүүд бий болгох талаар хэрэглэгчдээс тавьсан хүсэлтийг үр дүнтэй биелүүлэх боломжтой болно.
- Монголын Гаалийн байгууллага нь алдаа, дутагдлыг арилгах, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2003 онд Ёс зүйн болон сахилгын дүрэм, 2005 онд Үйлчилгээний стандартыг баталж гарган 2003 онд Сахилгын Хороог байгуулж ажиллаж байгаа боловч гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дутагдал доголдол байсаар байгаа тухай олон нийтээс мэдээлсээр байна. Ийм муу үйлдлээс ангид байх талаар ажилтнууддаа зориулан явуулах сургалтыг эрчимжүүлэх, дутагдал гаргасан ажилтнуудад хатуу арга хэмжээ авдаг байхыг Монголын Гаалийн байгууллагад зөвлөж байна.
- Хүний нөөцийг хөгжүүлэх талаар мастер төлөвлөгөө гаргах ёстой бөгөөд үүнд шинээр шаардагдах мэдлэг, сургалтад хамрагдах ажилтнуудын тоо, ангилал, сургалтын ерөнхий төлөвлөгөө, сургалт

явуулах багш нар болон шаардлагатай нөөц, санхүүжилтийн талаар тусгаж өгсөн байвал зохино. Энэхүү мастер төлөвлөгөөнд Монголын гаальд зориулсан цахим сургалтын зааварчилгааг тусгаж өгөх ёстой.

iii. Гааль, Эдийн Засгийн Дээд сургууль

- Гааль, эдийн засгийн дээд сургуулийн материаллаг баазыг сайжруулах шаардлагатай.
- Судалгааны ажил хийх, гаалийн болон холбогдох бусад сэдвээр дэлхийн болон бүс нутгийн сүүлийн үеийн ололт амжилтуудаас хоцрохгүйгээр мэдээлэл авах боломжийг багш, оюутнуудад олгох номын сан байх ёстой.
- Багш, оюутнуудад зориулсан гуанз, чөлөөт цаг, биеийн тамирын өрөө зэрэг байх хэрэгтэй байна.
- Одоогийн шинжилгээ судалгааны ажлуудыг хянан үзэж, тэдгээрийг гааль болон улс оронд бодит үр дүнтэй байхад чиглүүлэх байдлаар өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай.
- Хичээлийн нэр төрлийг хянан үзэж, эдгээр нь эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг магадлах хэрэгтэй
- Тус сургуулийн урт хугацааны стратеги, төлөвлөгөөг МУГЕГ-ын удирдлагын оролцоо, дэмжлэгтэйгээр гаргаж батлуулах шаардлагатай.
- Төгсөгчид гааль, гаалийн зуучлагч, тээврийн болон холбогдох бусад салбарт тэр бүр ажиллахгүй байгаа шалтгааныг судлах хэрэгтэй.

III. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ САНАЛУУД

Хөрөнгө оруулалтын зорилго

- Худалдааг дэмжих, төсвийн орлогыг нэмэгдүүлэх түүнчлэн Гаалийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг сахиулах зорилгоор МУГЕГ-ын чадавхийг бэхжүүлэх
- Мэдээлэл холбооны технологээр Монгол Улсад тэргүүлэх чиглэлтэй байгаа Монголын гаалийн байгууллагын байр суурийг улам бэхжүүлж, дэмжлэг үзүүлэх
- Хүнд суртлаас ангид, бизнест таатай ханддаг, Монголд хийгдэж буй худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжигч байгууллага

болгохоор Монголын Гаалийн байгууллагын үйл ажиллагааг тэлэх

- Төв Азийн Бүс Нутгийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөрийн Гаалийн Хамтын Ажиллагааны Хороонд Монголын Гаалийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тэргүүлэх чиглэлтэй болгох асуудлыг хөхүүлэн дэмжих

Агуулга, бүрэлдэхүүн хэсгүүд

i. Материаллаг баазыг сайжруулах зорилгоор бараа нийлүүлж, үйлчилгээ үзүүлэх

- Мэдээлэл холбооны мастер төлөвлөгөөнд дурьдсаны дагуу олон төрлийн мэдээллээс боловсруулалт хийж шаардлагатай шинэ мэдээлэл гаргаж авах, дүн шинжилгээ хийх болон бизнесийн тандалт хийх системийг агуулсан мэдээллийн автоматжуулсан нэгдсэн системийг үе шаттайгаар шинэчлэх
- Замын -Үүд, Алтанбулагт ачааны терминал барьж байгуулах
- Замын -Үүд, Алтанбулагт ашиглагдаж байгаа терминалуудыг зөвхөн зорчигчдод зориулсан байдлаар зохицуулан өөрчлөн шинэчлэх
- Улсын хилээр нэвтэрч байгаа авто тээврийн хэрэгсэл, галт тэрэгний хөдөлгөөнд хяналт тавьж, энэ талаарх мэдээллийг интернетээр дамжуулах хүчин чадалтай хяналтын төхөөрөмжийг хил дээр суурилуулах
- Хятад Улс руу ашигт малтмал экспортоор гаргадаг хилийн боомтоор нэвтэрч байгаа авто тээврийн хэрэгсэл, тэдгээрийн ачсан барааг автоматаар хянаж бүртгэх хүчин чадалтай болгох байгууламж бий болгох
- Гааль, эдийн засгийн дээд сургууль болон Эрэлч нохойн албаны материаллаг баазыг сайжруулах

ii. Техник туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиглэлүүд

а. Хууль хэлэлцүүлэх, батлуулах

- Эрсдэлд тулгуурласан сонгон шалгалт, бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх, гаалийн горимуудыг дахин шинэчлэх түүнчлэн түр хойшлуулах горим болон цахим мэдүүлгийг буруугаар ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх зэрэг асуудлуудыг зохицуулсан хууль дүрэм (хууль, эрхийн актууд)-ийг боловсруулах

b. Үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэслэлтэй шинэчлэл хийх

- АХБ-ны судалгаанд тусгасны дагуу Гаалийн горимуудыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүний арга барилд нийцүүлэн өөрчлөн шинэчлэх

c. Техник арга ажиллагааг сайжруулах

- Мэдээлэл технологийн тэргүүний техник арга ажиллагаа(олон төрлийн мэдээллээс боловсруулалт хийж шаардлагатай шинэ мэдээлэл гаргаж авах, дүн шинжилгээ хийх)-г хэрэглэх үйл ажиллагааны зааварчилгаа болон хэрэгжүүлэх систем, үүнтэй холбоотой гол бичиг баримтуудыг боловсруулах

d. Олон улсын худалдааг дэмжих, худалдааны аюулгүй байдлыг хангах талаарх Багц стандартыг хэрэгжүүлэх

- Эдийн засгийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн ажил үйлчилгээ эрхлэгчид(AEOs)-ийг болон хяналт шалгалтыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг баталгаажуулах

e. Киотогийн Шинэчилсэн Конвенцийг хэрэгжүүлэх үндэсний стратеги боловсруулах

- Монголын гаалийн багц хуулийг Киотогийн Шинэчилсэн Конвенцтай харьцуулж ялгаатай асуудлуудад дүн шинжилгээ хийж, зохицуулан нийцүүлэх талаар стратеги боловсруулах

f. Бүс нутгийн болон хоёр талт хамтын ажиллагаанууд

-
- Бүс нутгийн хэмжээнд зөрчлийн асуудлаар мэдээлэл цуглуулж, харилцан солилцох асуудлыг болон хилийн хамтарсан хяналт шалгалт, түүнтэй холбоотой арга хэмжээ авах асуудлыг хөгжүүлэх талаар онцгой арга хэмжээ авах

iii. Чадавхийг бэхжүүлэх

a. Сургалт

- Гаалийн шинэ техник арга ажиллагааг хэрэглэх, автоматжуулалтын нэгдсэн системийг шат дараатайгаар шинэчлэх асуудалтай уялдан шаардагдах шинэ мэдлэг олгох явдлыг дэмжих зорилгоор мэдээллийн технологийн анхан шатны болон гүнзгийрүүлсэн сургалт явуулах

b. Менежментийг өөрчлөх хөтөлбөр

- Орчин үеийн гаалийн байгууллагын зорилго, зорилтыг биелүүлэх, гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн чиглэлээр олон улсын практикт батлагдсан тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, автоматжуулалтын нэгдсэн системийг шинэчлэх, АХБ-ны судалгаанд тусгагдсан санал болгож буй бусад өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх алхмуудыг авах

iv. Судалгаа хийхэд зарцуулагдах санхүүжилт хийх

Доорх үйл ажиллагаануудыг явуулах, шинээр эхлүүлэх чиглэлээр хийгдэх төсөл, судалгааны ажлыг санхүүжүүлэх:

- Нэг цахим цонхны үйлчилгээ
- Хариуцлага хувааж хүлээх хөтөлбөр
- Хэмжүүрүүд: Барааг эзэнд олгогдох хүртэл зарцуулагдах хугацаанд болон худалдааны үр ашгийг тооцох судалгааг тодорхой хугацаанд тогтмол хийх,
- Олон улсын худалдааг дэмжих, худалдааны аюулгүй байдлыг хангах асуудлаар батлан гаргасан багц стандартыг хэрэгжүүлэх

IV. Хэрэгжүүлэх

Нийт хөрөнгө оруулалтад 8 сая ам.дол зарцуулах тооцоо гаргасан бөгөөд үүний 3 саяыг (үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэн) Монголын Засгийн газраас, үлдсэн 5 саяыг АХБ-аас санхүүжүүлэх боломжтой.

Учирч буй хүндрэл бэрхшээл, одоогийн мөрдөж байгаа гаалийн горимуудтай холбоотой саад тотгорын талаар АХБ-ны судалгаанд нарийвчлан тусгасан. Үндэсний хэмжээний Нэг Цахим Цонх бий болгох төлөвлөгөө, Мэдээлэл Технологийн мастер төлөвлөгөө тэдгээрийг шат дараатайгаар хэрэгжүүлэх үечилсэн цаг хугацааны талаар энэхүү судалгааны Хавсралтад оруулсан. Санал болгон дэвшүүлж байгаа арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд хамрагдах гол агентлагууд, албан газруудтай урьдчилан уулзаж, харилцан санал солилцсон боловч төсөлд тусгагдсан нарийвчилсан асуудлуудаар тэдгээртэй дахин сайтар ярилцах хэрэгтэй бөгөөд ингэснээр төслийг хэрэгжүүлэх ажлыг илүү үр дүнтэй болгоно.

